



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

□ 2018 оныг "Иргэдийн оролцоотой-Амьдрах
орчныг сайжруулах жил" болгон
зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 01/19 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас үзүүлж байгаа үйлчилгээг шинэ шатанд гаргаж, шийдвэр гаргах түвшинд иргэд, оршин суугчдын саналыг тусган, хотын хөгжил, бүтээн байгуулалт, тохижилтын ажилд тэдний оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангах зорилгоор 2018 оныг "Иргэдийн оролцоотой-Амьдрах орчныг сайжруулах жил" болгон зарласугай.

2. "Иргэдийн оролцоотой-Амьдрах орчныг сайжруулах жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

3. "Иргэдийн оролцоотой-Амьдрах орчныг сайжруулах жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг иргэн, төр, хувийн хэвшлийн байгууллагын саналыг тусган боловсруулж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хэлэлцүүлэн батлуулахыг энэ захирамжийн 2 дугаар зүйлд заасан Ажлын хэсэгт, нийслэлийн тохижилт, бүтээн байгуулалт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд иргэдийн оролцоог хангах зорилгоор "Манай хороо-Миний гудамж" аяныг 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл өрнүүлж, нийслэлийн өдрийн өмнө дүгнэхийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба /Т.Гантөмөр/-нд тус тус даалгасугай.

4. Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэхэд онцгой анхаарч, нэгдсэн удирдлагаар ханган ажиллаж, ажлын явц, үр дүнг улирал тутам Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж байхыг Нийслэлийн Засаг даргын дэд бүтэц, гэр хорооллын хөгжлийн асуудал хариуцсан орлогч П.Баярхүүд, "Иргэдийн оролцоотой-Амьдрах орчныг сайжруулах жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг олон нийтэд тогтмол мэдээлж, сурталчилж байхыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс /Э.Дагиймаа/-т тус тус үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



С.БАТБОЛД

1110200000013

Нийслэлийн Засаг даргын 2018 оны
01 сарын 02-ны өдрийн
захирамжийн давсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга -Нийслэлийн Засаг даргын дэд бүтэц, гэр хорооллын хөгжлийн асуудал хариуцсан орлогч
- Гишүүд:
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгчид /зөвшилцсөнөөр/;
 - Нийслэлийн Засаг даргын ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч;
 - Нийслэлийн нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч-Нийслэлийн Засаг даргын орлогч;
 - Нийслэлийн ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч-Нийслэлийн Засаг даргын орлогч;
 - Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга;
 - Нийслэлийн Засаг даргын Ахлах зөвлөх;
 - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга;
 - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга;
 - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга;
 - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга;
 - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга;
 - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга;
 - Багануур дүүргийн Засаг дарга;
 - Багахангай дүүргийн Засаг дарга;

- Баянгол дүүргийн Засаг дарга;
- Баянзүрх дүүргийн Засаг дарга;
- Налайх дүүргийн Засаг дарга;
- Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга;
- Сүхбаатар дүүргийн Засаг дарга;
- Хан-Уул дүүргийн Засаг дарга;
- Чингэлтэй дүүргийн Засаг дарга;
- Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын дарга;
- Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын дарга;
- Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газрын дарга;
- Нийслэлийн Газрын албаны дарга;
- Нийслэлийн Гэр хорооллын дэд бүтцийн газрын дарга;
- Нийслэлийн Боловсролын газрын дарга;
- Нийслэлийн Тээврийн газрын дарга;
- Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга;
- Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга;
- Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын дарга;
- “Нийслэлийн Орон сууцны корпораци” ОНӨҮГ-ын захирал;
- “Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” ХК-ийн захирал.

Нарийн бичгийн
дарга

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн дарга.